



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2020.09.01 № 1535

танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР
ДЭВШИХ ИРГЭН Ц.ПҮРЭВХҮҮ
ТАНАА

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд бие даан нэр дэвших иргэн Цэрэндоржийн Пүрэвхүүгийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Нийслэл, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвших иргэн нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон "Алсын хараа-2050", Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтод нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлэн хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвших иргэний сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, "Алсын хараа 2050", Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, нийслэлийн 2021-2022 оны төсвийн төсөөлөл, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт

Иргэн Цэрэндоржийн Пүрэвхүүгийн нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд бие даан нэр дэвшихээр ирүүлсэн сонгуулийн

мөрийн хөтөлбөр, түүнд тусгагдсан зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Иргэн Цэрэндоржийн Пүрэвхүүгийн сонгуулийн мөрийн хөтөлбөр (1. хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Нийслэлийн Сонгуулийн хороонд

Хавсралт: 1 хуудастай

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРДОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.НОМИНБААТАР



НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ
Цэрэндоржийн ПҮРЭВХҮҮГИЙН
2020-2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөр 2 хэсгээс бүрдэнэ.

1. Гэр хорооллыг хэсэгчлэн дэд бүтэцтэй болгохыг зорино
2. Гэр хорооллыг орон сууцжуулах ажлыг эрчимжүүлэхийг зорино

Нэг. 1. Гэр хорооллыг хэсэгчлэн дэд бүтэцтэй болгохыг зорино

- 1.1. Улаанбаатар хотын гэр хороололд дэд бүтэц хөгжүүлэх, хүн амын орлогод нийцсэн орон сууц нийлүүлэлтийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлнэ.
- 1.2. Төсвийн үрэлгэн зардлыг хянаж гэр хороололд дэд бүтэц барихад зарцууулахад нөлөөлнө. Ганцаараа нөлөөлж дийлэхгүй бол иргэдтэйгээ хамт тэмцнэ, шахна.

Хоёр. Гэр хорооллыг орон сууцжуулах ажлыг идэвхижүүлэхийг зорино.

- 2.1. Гэр хорооллыг орон сууцжуулах төслүүдийг бодитоор хэрэгжих эсэхийг богино хугацаанд шалгуулж тогтоолгоно.
- 2.2. Орон сууцанд орох хүсэлтэй гэр хорооллын иргэдийн эрх ашгийг хамгаалж ажиллана.
- 2.3. Гэр хорооллыг орон сууцжуулах төсөл хөтөлбөрт зориулагдсан бүтээн байгуулалтын ажлын нийт ажиллах хүчний 30 хувиас доошгүй нь тухайн бүсийн иргэд ажилладаг байх эрх зүйн зохицуулалтыг бий болгохыг зорино.

Цэрэндоржийн
Пүрэвхүүгийн
10/1/2024

